

ШИНЖААНЫ ОЙРАДЧУУДЫН ТӨРӨЛ САДНЫ ДУУДЛАГА БА НИЙГЭМ СОЁЛ¹

Соёл

Хураангуй: Ойрад монголчуудын төрөл садны дуудалгын систем бол ойрад аялгууны үгийн сангийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох мөртөөн ойрад монголчуудын нийгэм соёлын өвөрмөц онцлогийг илрүүлж чадахуйц чухал соёлын үгс байдаг. Өгүүлэлд голдуу Шинжааны ойрад монголчуудын төрөл садны нэрд утгын задлалт хийхээр дамжин бусад газрын монголчуудынхаас ялгагдах өвөрмөц онцлог шинж ба агуулагдах соёлын агуулахуунд задлалт хийжээ.

Түлхүүр үг: *Ойрад, ойрад аялгуу, төрөл садны нэр, нийгэм соёл судлал*

Төрөл садны нэрийн тогтолцоо бол нийгмийн байгуулал, ураг хуримын дүрэм, гэр бүлийн ёсны улирал хувьсалтай харьцуулбал нэлээд тогтвортой байдаг. Гэвч тэр нь эдгээр бүхний улирал хувьслыг тусгах түүхийн урт удаан явцад гүн зузаан соёлын агуулгыг хуримтлууж ирсэн бөгөөд төрөл садны дуудлага болох нэг бүрийн утгын онцлог шинжээр дамжин биелэлээ олдог. Тус өгүүлэлд ойрад монголчуудын төрөл садны нэрээс онцлогтой үгсийг сонгож, түүний соёлын агуулахууныг задлахаар дамжин ойрад монголчуудын овгийн нийгмээс феодалын нийгэм, нийгэм журамт нийгэмд шилжих түүхийн явц дахь улирал хувьслыг шинжлэе.

Нэг. Шинжааны ойрадын төрөл садны дуудлага хийгээд Монголын эртний овгийн байгууллын эрх мэдэх ёс, үе залгамжлах дүрмийн улбаа

Ойрад аялаганы авга ба ач гэх дуудлага нь доорх хэдэн төрлийн харьцааг илтгэдэг.

Авга - Эцгийн ах; эцгийн дүү; эцгийн ахын хүүхэд;

Ач - Эгчийн дүүгийн хүүхэд; өөрийн ах дүүгийн хүүхэд; өөрийн хүүгийн хүүхэд;

Хэрэг бодисын нэрийдлийн бий болох бол бүр зохих нэгэн үндэслэлтэй байдаг. Ойрд монголчууд яагаад эцгийн ахын хүүхдийг авга, эцгийн дүүгийн хүүхдийг ач гэдэг вэ? Үүнд гүн зузаан нийгм түүхийн үндэс шалтгаантай байдаг. “Шинжианы цахарчуудын зан үйл” гэх номд нэг аав ээжээс гарсан хүүхдийн ууган ах нь хэдэн үе дамжсан ч хамаагүй айлынхаа ах нь, дээлийн зах нь болж суудлынхаа эхэнд сууж, идээний дээжийг авж байдаг. Хойших үр хүүхэд нь энэ айлыг *их айл, ах айл, ах өрх* гэж хүндэлдэг (Гомбо, 2004:5) гэсэн ба Баянголын хошууд монголчуудын дунд *насаар ах заяагаар ахыг гүйцэхгүй* гэж баяар ёслолд бурханд

¹ Тус өгүүлэл Өвөр Монголын Өөртөө Засах Орны гүн ухаан, нийгмийн шинжлэх ухааны сэдэв *Ойрад аялгууны үгсийн сан хийгээд зан үйл судлал* (2015B091) төслийн үр дүн болно.

цацал цацдаг нь эрхбиш төрлийн ахлагч байх хэрэгтэй². Ойрд аялганд *төрлөө мартсан хөвгүүн муу, төрхмөө мартсан хүүхэн муу* гэдэгчлэн энд хэлж байгаа төрлийн ахлагч бол нэг аавын олон хүүхдийн ууган ах жич түүний ууган үр хойчсыг зааж байдаг.

Эрдэмтэн Д.Гонгор “Овгийн өв хөрөнгийг тухайн овог буюу эцгийн ууган хөвгүүн залгамжлаж,гал голомтыг сахин уламжилдаг” гэсэн ба “Харц ардийн хөвгүүд насныхаа эрмбэ дэсийн дагуу эцгийн хөрөнгөөс хувь авах эрхтэй бөгөөд түүнийг *өмч хуваах* гэж нэрлэдэг”, “Ноёд, тайж нар уг удмын нэрсийн хэлхээ данс гэрийн үеийн бичимлийг нарийн чанд хөтөлвэрлэж түүнийгээ мөрдөн уул асуудлыг шийдвэрлэж байв” (1990:250) гэжээ. Эрдэмтэн Х.Дамбийжалсан “Монголын жижиг гэр бүлийн эзэн нь эцэг хүн байсан. Эцэг бол гэр бүлд хамгийн хүндэтгэлтэй, эрх сүртэй хүн билээ. Эцэг нь нас барсан бол ахмад хөвгүүн нь гэрийн эзнийг оролдог. Энэ нь аль эртнээс уламжилсан (хүн ахтай, дээл захтай) гэх хэв заншил билээ” (1995:471-472) гэв. Овгийн байгууллаас боолт байгуулал, феодалын байгуулалт шилжих бүх явцад *Ах* хүний эрх зэрэг, өв хөрөнгө нь бүр дүүгээс давамгайлж байсан байна. Энэ байдал Монголын нууц товчоо-д ч тусгагдсан байна. Жишээлбэл: Чингис хаан их Монгол улсыг байгуулж хувь өмч хуваасан тухай §242-д “Улс хуваан зовогсод эх буюу. Хөвгүүдийн минь ах Зүчи буй. Дүү нарын минь нялх Очигин буй” хэмээж эхэд Одчигиний хувь хийгээд түмэн иргэн өгөв... Зүчид есөн мянган иргэн өгөв. Цагаадайд найман мянган иргэн өгөв. Өгэдэйд таван мянган иргэн өгөв. Тулуйд таван мянган иргэн өгөв...” (Элдэндэй, Ардажав, 1986:779) Энд ахмад хөвгүүн Зүчийн олсон өмч иргэн хамгийн олон болж байна. §270-д “Хөвгүүний ах аялбаас цэрэг арвин гарах” (Элдэндэй, Ардажав, 1986:893) гэдэг нь мөн ч ахмад хөвгүүний өвлөх өмч иргэн нь олон болохыг тусгаж байна. Бас §275-д Бат Хибцагчин аян дээрээс Өгэдэй хаанаа элчнээс өчиж иррүн: “Би эд бүхэн хөвгүүдийн ах нь болсон болж. Нэгэн хоёр аяга өтөг урьд уув хэмээн надур бүр, гүег хоёр магуулж хурим үл хуримлан морилогдов”-д (Элдэндэй, Ардажав, 1986:917) мөн ч ах хүний эрх сүр байр суурийн өндөр байхийг илрүүлж байна. Жишээлбэл: §23-д “Эх юун Алунгоог үгүй болсний хойно ах нар дүү нар тавуул адгуусан идээгээ хуваалдрун, Бэлгүндэй, Бөгүдэй, Бугу хадих, Бухт салжу дөрвүүл авалцав. Буданцар мунхаг ядуу буюу хэмээн ураг үл тоон хувь эс өгөв” (Элдэндэй, Ардажав, 1986:21). §11-д “Дува сохор үгүй болсний хойно дөрвөн хөвгүүд инү Добу мэргэн авга юугаа үл болгоон доромжилж хагацаж гэж нүүв” (Элдэндэй, Ардажав, 1986:39) зэргээс үзвэл овгийн байгууллын үед ах хүний өв хөрөнгө, эрх сүр, байр суурь нь өндөр байх ба түүний залгамжлагчид ч адилхан эрх сүр байр суурьтай байхыг мэдэж болно. Яг иймээс дүү Буданцыг ургаас гаргах, авга Дува мэргэнийг ураг үл болгон доромжлох хэрэг үүссэн байдаг.

Дээрхээс үзвэл *Ах* гэх үг нь овгийн байгууллаас боолт байгуулал, феодалын байгуулалд шилжих түүхийн урт удаан явцад, дан ганц насаар их гэх утгийг л биш харин өв хөрөнгөтэй, эрх сүртэй, нэр хүндтэй, үе залгамжлах нийгмийн байр суурьтай гэх мэтийн далд утгийг агуулах болсон байна. Тэгээд үгийн утгийн хөгжлийн явцад *Ах* гэх үг олон салбар утгатай болжээ. Овгийн байгууллын үед овгийн бүх гишүүдийг хамааран захирдаг овог аймагийн түрүү-овгийн ахлагч буюу аймгийн ахлагчтай адилаар Шинжиан Уйгар үндэстний өөртөө засах орны Илийн Хасаг үндэстний өөртөө засах жоугийн Монгол Хүрээ сияанд *Ах* Суман Ч.Суман Д.Суман Н.Суман Т.Суман Б.Суман гэх зургаан Суман өөлд монгол байх ба *Ах* Суман нь бусад 5 сумнаан захирдаг байна³.

Ойрад монголчууд гийч хурим болоход заавал гийчийн ахлагч (толгойлогч)-ыг сонгон тогтоодог бөгөөд гийчийн бүх явц нь түүний тохируулгаар явагддаг. Эдгээр нь нэг талаар овгийн байгууллын ахлагчийн эрх мэдэх ёсны ул мөр болох бөгөөд *Төрлийн ахлагч* гэвэл тухайн төрлийн дотооддоо хамгийн өндөр байр суурьтай байж төрлийн бүх гишүүдийнхээ

² Зохиогчийн 2005 оны зун Шинжааны Баянголын монгол үндэстний өөртөө засах жоугийн Хошууд сиянийн бууц малжлын талбайн Лираб настныг сурвалжилсан тэмдэглэл.

³ Зохиогчийн 2005 оны 8 сард Шинжаан Уйгурын өөртөө засах орны Или хасаг үндэстний өөртөө засах жоугийн Монгол хүрээ сиянийн Бэхшиг багшийг сурвалжилсан тэмдэглэл.

хүндэтгэлийг олдог. Энэ нь Монголын эртний угсаа залгамжлах ёсны үлдэгдэл болж байна. Жишээлбэл Дээд Монголын аман аялганд *Ахлагч* гэвэл толгойлогч, Ах, дээд: манай хүүхдүүдийн ахлагч нь их сургуульд явчлаа (Норжин, Чойдандар, 1992:383) гэх мэт. Монголын нийгмийн үе залгамжлах уламжлал нь орчимхон болтол нэг овог буюу эцгийн шугамыг баримтлан нэг газар малжиж байсан ойрд монголчуудын дунд одоо болтол хадаглагдаж байна. Ойрад монголчуудын дотор нэгн аавын олон хүүхдийн ууган ах жич түүний ууган үр хойчис нь энэх төрлийн төрөл сунжирах, төрөл аглахших болтол ахлагчын байрд байдаг. Иймээс энэ төрөл дотор эцгийн ах жич түүний хүүхэд нь төрлийн бусад хүмүүстэй харицуулбал байр суурь нь өндөр болхоор хамтдан *Авга* гэж хүндэтгэн дуудах болсон нь дамжиггүй. Энэхүү мөрдөлгийг (авга) гэх үгний бүтцээс ч мэдэж болно. Эрдэмтэн Г.Хайрхан Б.Содын “Монгол хэл хийгэд монголчуудын уламжлалт соёл” (Хайрхан, Сод, 2001:110) гэх номд авга гэх үг аав+ах> абух ~ абуга > авга болсон гэжээ. Энэ мөрдөлтөөс бид *Авга* гэх дуудлагад ааваас эрх сүртэй, байр суурьтай гэх агуулахуун байхыг мэдэж болно.

Ойрад аялгуун дахь авга гэх дуудлага бол Монголын эртний эцгийн эрхт гэр бүлийн ахмад хөвгүүн даруй ууган хөвгүүн өмч залгамжлах ба угсаа залгамжлах ёсноос ирэлттэй нэг зүйлийн төрлийн харьцааны дуудлага юм.

Хоёр: Шинжааны ойрадын төрөл садны дуудлага хийгээд эмэгтэй хүний нийгмийн байр суурийн хувьралт

Ойрад аялгуунд эмэгтэй хүүхдийг нийт монгол хэлэнд нийтлэг хэрэглэгдэх (хүүхэн, охин) гэж дуудахаас гадна *Муу хөвүүн, жүгэр, ноёхон, гилай (гилаан), сэвгэр, гээгэтэй, нөхөөрэн* гэх мэт хэдэн зүйлээр дуудаж байна. Эдгээр дуудлага нь нийгмийн хөгжилтийн адил бус түүхэн шат үед бий болж үүссэн бөгөөд гүн зузаан соёлын агуулхуунтай байдаг.

Муу хөвүүн - Ойрад монголчууд эрэгтэй хүүхдийг *Сайн хөвүүн* буюу *Сайн* гэж, үүний эсрэгээр эмэгтэй хүүхдийг *Муу хөвүүн* буюу *Жүгэр* гэдэг. Энэ нь өнгөрсний ойрадын нийгэм дэх эрэгтэй, эмэгтэйн тэгш бус нийгмийн байр суурийн төрлийн харьцааны дуудлага дахь тусгал болно. Ойрад Цагаач-д нийгмийн бүх гишүүдийг зэрэг дэс, эд хөрөнгөөр нь *Сайн, Дунд, Муу (адаг)* гэж хувиарлаж байсан ба эрэгтэй, эмэгтэйн нийгмийн байр суурийн тэгш бус байдал ч тусгагдсан байдаг. Жишээлбэл: 99-р зүйлд *Боол эмээс гэрчид тоогүй* гэгчийг хажуугийн тайлбарт Дайн болбоос эр боол гэрч болох эрхтэй байх ёстой... Эр боол ба эм боолын адил бус байр суурийг илтгэж байна (Дорнотив, 1985:169) гэжээ.

Гэр бүл бол нийгмийн үндсэн нэгж бөгөөд нийгмийн цомхотгол дүрс мөн. Эрэгтэй, эмэгтэйн нийгмийн байр суурийн хувирал нь гэр бүлийн дотоодод тусгалаа олох нь лавтай байдаг. Ойрадоод ураг салсан буюу бэлэвсэн бүсгүй ерөөс хүүгээ дагуулж харьд гарах ёс байдаггүй. Хүүгээ эрхбиш эцэгт нь эсвэл эцгийнх нь садан төрөлд нь буюу суман элгэнд нь үлдээж, хүүхнээн эх нь авч явж болдог (Гомбо, 2004:3). Энэ нь эцгийн эрхт овгийн байгууллын угсаа залгамжлах уламжлал дахь хүүг хүсэж, хүүхэн гадуурчлах үзэл ухамсрын үзэгдэл оршиж байхын тусгал болно. Өөлд монголчуудын дунд сая хүүхэдтэй болсон гэрийн хүнтэй уулзвал *Эмээл хазаар тохих уу? Товч шилбэ хадах уу* гэж хүү, хүүхэн аль нь болохыг лавладаг. Энэ нь эрэгтэй, эмэгтэйн нийгмийн ажлын хуваарийг тусгаж байна. Шинжиан цахарчууд бол цэрэг гаралтай, эрэгтэйчүүд цэргийн алба хааж хил хязгаар сахих нийгмийн үүрэг чадал, ажлын хуваарилалттай холбоотой бөгөөд *Хүү гарвал цэргийн дансанд авч, гунан наснаас эхэлж сард 3 жин цагаан мөнгөн цалин* өгдөг (Гомбо, 2004:3) бодит явдал нь эрэгтэй хүний нийгмийн байр суурь эмэгтэйчүүдийнхээс өндөр болох бас нэг шалтгаан болж байна.

Ан агнал, нүүдэл малжлыг эрхлэн амьдарж байсан ба ахин дахин үүсэх пиодалын дайны хөл үймээний дунд эрэгтэйчүүд бол нийгмийн гол тулгуур хүчин болж байлаа. Иймээс эцгийн эрхт овгийн байгууллын угсаа залгамжлах уламжлал ба нийгмийн ажлын хувиарлалд суурилсан пиодалын нийгмийн Эрэгтэйг хүндэтгэж, эмэгтэйг хөнгөвчлөх дүрст

болсон Сайн хөвгүүн ~ Сайн, Муу хөвгүүн ~ Жүгэр гэх хүү охиноон дуудах дуудлага нь хэлний заншилын хүчиний нөлөөнд одоо болтол Ойрд Монголчуудын дунд яригдсаар байна.

Нөгөөрэн хүүхэд - *Харьд морьдсон хүүхэн / Харваж гаргасан сум, Хадамд өгсөн хүүхэн / Хаданд цохигдсон чулуу* гэхчлэн Ховогсайрын торгууд монголчуудын хүүхэн үрээ дуудах нэг зүйлийн дуудлага мөн. Тус үг нь *Нөгөө+гэр+ийн* гэх бүтэцтэй, хэлний хэлхээндэх авиа товчлогдох жимээр *гэ-* үе товчлогдсон байна. Энэ нь Монголын нийгмийн эхчйлэлийн овог төрлөөс эчигчйлэлийн овог төрөлд шилжхийг дагалдан эмэгтэйчүүд эрэгтэйн талд хөргөгдөн очих болсон хуримын зан үйлийн дүрст болно. Ойрад эмэгтэйчүүд хуримлахаасаа урд нэрийн өмнө аавынхаа нэрээр тодотгол авч байсан бол хурималсны дараа эр нөхрийнхөө нэрээр тодотгол авдаг заншил нь ч энэхүү зүйлийн ураг хуримын дүрмийн гүн гүнзгий нөлөө тусгалыг харуулж байх төдийгүй пиодлын гэр бүлийн ёсондох эрэгтэй хүний эрх сүрийн тэмдэг болж байна.

Ноёхон - Ойрад аялгад охин хүнийг хүндэтгэх буюу хөөрхийлэн дуудах дуудлага, жишээлбэл *манай ноёхон, танай ноёхон* гэх мэт. Тус үг *ноён+хан* бүтэцтэй байж, ноён язгуртны хүүхдийг дуудах дуудлага байснаас зэрэг дэсийн ялгалгүй нийдэм хэрэглэгдэх болжээ. Эрдэмтэн Г.И.Рамстедт: ноён гэж бан гүн, ноёхон гэж баг ноён буюу хошой авхайг заана. Эм хүйсийн ч багыг заах -хан / -хэн хэлбрээр илтгэж болно (芬兰, 1981:270). -хан / -хэн дагаварын утгын улирал хувьсалын тухай эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгээс “Хүү ба хүүхэн гэдэг үгийн учир” гэх өгүүлэлдээ тодорхой ярьсан байдаг. Түүнээс хүү ба хүү авиа утгийн тохиролцоог нотолсон суурин дээр хүү гэдэг үгэнд -хэн залгалтыг нэмээд анх хүүг энхрийлэн дуудах утгатай байснаасаа аажмаар хүүхэн гэх утгатай болжээ (1958) гэв. Бас эрдэмтэн Г.И.Рамстедтээс “Халимаг хэлэнд ноёхон гэвэл ваншийн хөвгүүнийг заана” (芬兰, 1981:60) гэжээ. Үүнээс зүйчилбэл, ойрад аялгуунд *Ноёхон* гэх үг хамгийн анх вангийн хөвгүүн - бага ноёныг зааж байснаасаа ноёны хүүхдийг заах болж, одоо хүүхэд хүнийг хүндэтгэх буюу энхрийлэх утгаар хэрэглэх болжээ.

Сэвгэр ~ Сэвгэрт, Гээгтэй - Хуримлаагүй хүүхний дуудлага болно. “Эртний монголчууд үүхдийн гээг, эр хүний гээг, охины гээг, эхнэрийн гээг гэж тус тус ялгал бүхий гээг тавих ёстой байжээ”⁴ 19 гэдэгчлэн эдгээр дуудлага нь монголчуудын гээг тавих ёс, гээгний заслын улиран хувьсахтай холбоотой.

“Монгол үгсийн язгуурын толь” (Цэцэнцогт, 1988:1519)-д Сэв(лгээ) 1) гээгний хүндэтгэл, сэвлгэр, шивлгэр сэбэргэл ч гэдэг байжээ, 2) тэв гээг, 3) хүүхдийн гээг, 4) (шил) зарим ургамлын сахлаг үс сахал гэх утгатай гэжээ.

Халхчуудын дунд хүүхдийн даахь (сэвлэг) авах үсний найр байдаг бөгөөд “...Бүстэй хүүхдийн онгон сэвэлгийг бүгдийг нь авчих ...бүс үгүй хүүхдийн даахиас сонжоо тавьж...” (Бадамхатан нар. 1990:577) гэхээс үзвэл бүстэй хүүхэд ба бүсгүй хүүхэд нь гээг үлдээх эсэхээрээ ялгаатай байна. Сэвлэгт ~Сэвгэр гэж тухайн онцлогт харгалзуулан дуудах бол монголчуудын хэрэг бодисыг нэрлэх заншил ба монгол хэлний үг бүтээх ёсонд зохицож байдаг. Монгол хэлэндэх *л~р* авианы сэлгэцэл ба авианы тонгорлын жам ёсыг үндэслэвэл ойрад аялгуун дахь *сэвгэр~сэвгэрт* гэх үгсийн бүрэлдсэн явцыг ойлгож болох юм.

Дахивал бүс үгүй хүүхдийн сонжоогоос 14~16 нас хүрхээр нь тэв гээг, тэвэг, гол үс тавиад 18~19 настайд нь их үс буюу гээг тавьдаг (Бадамхатан нар. 1990:578). Ховогсайрын торгуудчуудын ярианд *гээг* гэвэл гавлын хойд талын хэсэг буюу тэр хэсэгт ургасан урт үсийг заадаг. Хүүхэн хүүхэд наян найман гээгтэй⁵ гэж хэлэх нь бүсгүй хүүхдийн бүстэй хүүхдээс ялгагдах бас нэгэн онцлог болж байна.

⁴ Зохиогчийн 2005 оны 9 сард Шинжаан Уйгурын өөртөө засах орны Баянголын монгол үндэстний өөртөө засах жоугийн Хошуун сиянийн Бямба багшийг сурвалжилсан тэмдэглэл.

⁵ Зохиогчийн 2005 оны зун Ховогсайрын монгол үндэстний өөртөө засах сиянийн Намын сургуулийн ахмад кадр П.Никаг сурвалжилсан тэмдэглэл.

Плано Карпины жуулчлалын тэмдэглэл, Вильям Рубруккийн жуулчлалын тэмдэглэл, Чан Чун бумбын баруунш аялсан тэмдэглэл зэрэгт эрэгтэйчүүд бүр хоёр салаа гээг гүрдэг гэх мэдээ байх ба Норжин, Чойдандар нарын “Нутгийн аялгын үгсийн хураангуй” тольд Гээг - охид ба харчуулын ардаа ганц гүрсэн үс. Авгай хүний хувааж гүрсэн үсийг гээг гэхгүй үс л гэнэ (Норжин, Чойдандар, 1992:425) гэжээ. Иймээс ойрад аялгуун дахь гээг гэх дуудлага бол эрэгтэй хүн охор үс тавих болсон ба эхнэр хүн гээгээ хувааж гүрэх болсон үед бий болсон дуудлага болно.

Сэвгэр ~ Сэвгэрт ~ Гээгтэй гэх дуудлагад монголчуудын гээг тавих ёс ба гээгний заншлын зан үйлийн улирал хувьслын ул мөр харагдаж байхыг гаргавал бусад ямар ч сэтгэлгээний өнгө будаг байхгүй юм. Энэ нь эрэгтэй, эмэгтэйн нийгмийн байр суурь эрх тэгш болсон цаг үед бий болсон дуудлага болно. Дахивал өнгөрсөнд баяд ноёд, язгууртан, тайж нарын авхай хүүхэдийг дуудаж байсан Ноёхон, гялай ~ гялган (гэрэл гялбаа гэх утгатай) гэх мэтийн дуудалгыг анги давхаргын ялгаагүйгээр хүүхэд хүнд нийдэм хэрэглэх болсон нь эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийн дээшилснийг харуулж байна.

Нийгмийн хөгжилтийг дагалдан өнгөрсний баяд, ноёд, язгууртанд хэрэглэгдэж байсан дуудалга үг одоогийн ойрад аялганд нэгэнт зэрэг дэсийн ялгаагүйгээр хүндэтгэлийн утгаар буюу энгийн утгаар түгээмэл хэрэглэгдэж байна. Жиш:

Авхай – Хатан, хатагтай. Эрхэм язгууртны гэрийн эзэн бүсгүй. *Абай гэрэл хатан* (Халимаг Жангар, 1101) гэх мэт. Энэ үг ойрад аялганд ээжээ дуудах дуудлага болжээ.

Агаа – Хатан, хатагтай, гэргий. Урдын ерөөлөөр учирсан агаа ноён... (Халимаг Жангар, 1103) гэх мэт. Бас “Ойрад цааз”-ын 13-р зүйлд “Их ноён агаа чилээрхлээ” гэх мэтээр *агаа* гэх үг нь бүр ноён гэх үгтэй хоршин илэрч байжээ. Энэ үг одоогийн ойрад аялгуунд эгчмэд хүнийг хүндэтгэн дуудах дуудлага болсон байна.

Дээр ярьсан шигээр ойрад аялгуун дахь *Муу хөвүүн, жүгээр, ноёхон* мэтийн хүүхэн хүнийг дуудах дуудлага үгст эмэгтэйчүүдийн нийгмийн байр суурийн хувиралт маш ил тодорхой тусгагдаж байна.

Гурав. Шинжааны ойрадын төрөл садны дуудлага хийгээд эртний ураг хуримын дүрмийн ул мөр

Төрөл садны дуудлага бол нийгмийн хөгжилтийн адил бус шат үе дэх ураг хуримын дүрэм, жич түүнд суурилсан гэр бүлийн харьцааны тусгал болно. Гэхдээ тэр нь ураг хуримын дүрэм ба гэр бүлийн хэлбэрээс харьцангуй тогтвортой байж, тэрхүү дуудлагын бий болсон тухайн цаг үеийн соёлын агуулахуунаа урт удаан хугацаанд хадгалж байдаг.

Ойрад аялгууны төрөл садны дуудалгын систем нь ерөнхийдөө аймаглал маяг ба тодорхойлол маягийн холимог шинжтэй байдаг. Үүнд аймаглал маягийн төрөл садны дуудлагад Монголын эртний ураг хуримын дүрмийн улирал хувьслын им тэмдэг хамгийн гүн зузаан хадгалагдаж буй. Энэ маягийн дуудалгад *нагац, зээ, худ, авга, ач, хүргэн, бэргэн, бэр* гэх мэт олон байна.

Нагац - Хүний эх нь нагац, усны эх нь булаг, *Нагацын шар нохой ахлана* гэж эх, эмэг жич түүнээс дээд үеийн эмэгтэй дээдсийн төрхөмийг хамтруулан дуудах дуудлага болно.

Зээ - Өөрийн охин, жич түүнээс доод үеийн хүүхэд, эгч, эмэгтэй дүүгийн хүүхэд, авга эгч, жич түүнээс дээд үеийн эмэгтэй дээдсийн үр хүүхдийг хамтруулан дуудах дуудлага болно.

Худ ~ худгай - Эл үеийн хүргэдийн төрөл ба бэрээдийн төрхөмийг хамтруулан дуудах дуудлага болно. Үүнд ойрад аялагууны цахар аман аялага ба Тэхэсийн дөрвөн сум шавь нарын ярианд *худ* гэхгүй харин *худгай* гэдэг. Ургийн хоёр тал харилцан худгай гэх бөгөөд ураг тогтоохыг *худгай болох* гэдэг.

Ойрад аялагуунд яагаад эцгийн талын гол хэлхээний төрлийн харьцаанд нэг нэгийн харгалзасан дуудлага байхад эхийн талын төрлийн харьцаанд аймаглал маягийн төрөл садны дуудалгаар голлон үе нас ялгадаггүй вэ? Энэ тухай эрдэнтэн Д.Гонгор “Ураг төрлийн эцгийн талын авга, ач есөн үе уламжилж сайн хадгалгдсан байхад нагац зээгийн хэлхээ холбоо үлэмж богиноссон нь... нэг, эхийн эрхт ёс бол хүний нийгмийн анхны элэр балай үе болохын учир түүний ул мөр түрүүнд арилж улирах нь лавтай. Хоёрт, бидний мэдэж байгаагаар Монголын нийгэмд эцгийн эрхт феодалын харьцаа мянга гаруй жилийн өмнөөс ноёрхож эхэлсэн нь эхийн эрхт ёсны улбааг улам бүдгэрүүлж үгүйсгэх гол шалтгаан болжээ” (1983) гэж үзсэн байна. Манай үзэхээр энэхүү аймаглал маягийн *нагац*, зээ, худ мэтийн төрөл садны дуудлага нь эрдэмтэн Д.Гонгорын дүгнэсэн хоёр зүйлийн шалтгаанаас гадна эртний монголчуудын овгийн гадна ураглах ураг хуримын ёс заншил ба үе хутгалдан хуримлах ураг хуримын заншлаас үндэс сурвалжтай болно. “Монголын бүх овог буюу овогт нийгэм *ураг, харь* хэмээн хоёр үндсэн хэсэгт хуваагдана” (1983) гэсэн ба зэдийн дотроо түргүүд тухайлбал гэргийн талын төрөл садан болох овог буюу овог төрлүүд ба аймгийн салбар багтаж байдаг. Иймэрхүү овгийн гишүүнийг жинхэнэ зэдээр үздэггүй харин худ гэж хүндэтгэн нэрлэдэг байна” (Владимирцов, 1980:124) гэсэн нь ил тодорхой овгийн гаднах хуримлах ёсны тайлбар болж байна.

“Эртний үеийн нэг овгууд нь овгоороо нэг доор маллах бололцоотой байсан үед бүх овгийн төрөл саднаар эсвэл хамт нийтээрээ нэг хүрээ буудалладаг” (Владимирцов, 1980:119). Иймэрхүү аж ахуйн амьдрал нь овог төрлийн хоорондох харицааг нягтруулж, эцгийн шугамыг баримталсан овгийн дотоодын төрлийн харицааны дуудалгыг олшируулахад, эхийн шугам алс хол харь нутгаар амьдрах нагацын системийн төрөл садны дуудлага харьцангуй цөөхөн буйн нэг шалтгаан болж байна. Хэл бол хүмүүсийн харилцааны багаж мөн. Харилцааны агуулга нь хэлийг тогтоодог. Иймэрхүү нагац зээгийн урт хугацаагаар харилцахгүй бодит нөхцөл нь тэдний хоорондох үе, нас ялгах шаардлагагүй бөгөөд түүнийг ялгах нь ч хэцүү байдаг. Нөгөө талаар үе хутгалдан ураглах ургийн хэлбэр нь ч эдгээр нэрийдлийн нарийсаж чадахгүйн бас нэг шалтгаан болно. Жишээлбэл: Чингис хаан ба түүний хөвүүн Зүчи, Тулуй тус бүр хэрэйдийн Ван хааны ач хүүхэнтэй хурималсан ([波斯], 1985:215), ойрадын Хутуга бэхийн хоёр хөвүүн Дөрөлч, Иналч тус бүр Чингис хааны охин Цэцэхэн ба Зүчийн хүүхэн Хулаихантай хурималсан ([波斯], 1985:195), ойрадын Эсэн тайшийн эгч зүүн Монголын хан Тогто бөхтэй хурималсан, жич Эсэний хүүхэн дүү нь Тогтобөх ба энэхүү эгчээс гарсан хүүтэй хурималсан (³³) зэрэг тэмдэглэл нь эрт цагийн монголчуудын үе хутгалдан хуримлах заншил ойр үе болтол ойрадын дунд үлдэж ирснийг харуулж байна. Даруй энэхүү ураг хуримын замшил дүрэм нь тухайн үед нагац зээгийн хооронд үе ялгах нийгмийн суурийг бүрдүүлж чадахгүй мөртөөн хүргэн, бэрийн хооронд ч үе ялгаж чадахгүй байдаг. Үүнийг Монголын нууц товчоо-ны 202 дахь зүйлд Бух хүргэн, Бод хүргэн, Алч хүргэн, онгодын Алхуш дигид хори хүргэн... (都兴智, 1994) зэрэг үе ялгалгүй хүргэн гэж дуудаж байсан уламжлал одоогийн ойрад монголчуудын дунд хадгалагдсаар байна. Ойрад аялгуунд авга эгчийн хүргэн, эгчийн хүргэн, нагац эгчийн хүргэнийг бүр *хүргэн ах* гэж нэгдэлтэй дуудах ба хүүхэн дүүгийн хүргэн, ач хүүхний хүргэн, зээ хүүхний хүргэнийг бүр *хүргэн хөвүүн* гэж дууддаг. Үүнтэй харгалзаад авгын эхнэр, ахын эхнэр, нагацын эхнэрийг бүр *бэргэн* гэж, дүүгийн эхнэр, хүүгийн эхнэр, ачийн эхнэр, зээгийн эхнэрийг бүр *бэр* гэж дууддаг. Үүнд нэлээд олон эрдэмтдээс монгол хэлний хүргэн, бэргэн, бэр зэрэг төрөл садны дуудалгыг шинжлээд *хүргэн* гэх үг бол эхчлэлийн овог төрлийн үеийн хүүгээ хүүхний талд хүргэж байсан ургийн ёсны ул мөрийг харуулж байна гэжээ. *Бэр* гэх үг бол барьж авах гэсэн утгаас үүсэл бүхий эцэгчлэлийн овог төрлийн булаах ургийн үр дүнд бий болсон юм. *Бэргэн* гэх үг бол *бэр* гэх үгтэй гарал нэгтэй байж, эртний монголчуудын залган урийгн бүтээгдэхүүн мөн (哈斯巴特尔, 1994) гэсэн ба худ гэх үгээс зүйчлэн эртний Монголын нийгэмд худалдаан ураг байсан (文英, 2003) зэрэг дүгнэлтийг гаргасан юм.

Дүгнэлт

Гэр бүл бол бүхэл нийгмийн цомхотгол дүрс мөн. Нийгмийн хөгжил хувирал нь гэр бүлийн ёсонд тусгагддаг. Ойрад монголчуудын төрөл садны дуудлагад овгийн байгууллаас эхтэй эл цаг үеийн нийгмийн байгууллын угсаа залгамжлах, өв өвлөх, эзэмших эрх хийгээд хүмүүсийн нийгмийн байр суурийн хувирал, ураг хуримын ёсны улирал хувьслын ул мөр хадгалагдаж байна.

Номзүй

[波斯]拉施特《史集》第一卷，第一分册，商务印书馆，1985年。

Бадамхатан С. нар. *БНМАУ-ын угсаатны зүй.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1990. (монгол бичгээр)

Владимирцов Б.Я. *Монголын нийгмийн байгууллын түүх.* Үндэстний хэвлэлийн хороо. 1980. (монгол бичгээр)

Гомбо Г. *Шинжааны монголчуудын зан үйл.* Шинжааны шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. 2004. (тод үсгээр)

Гонгор Д. *Халх товчоон.* Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1990. (монгол бичгээр)

Дамбийжалсан Х. *Монгол зан үйлийн зүй.* Лиониний үндэстний хэвлэлийн хороо. 1995. (монгол бичгээр)

Дамдинсүрэн Ц. *Хүү ба хүүхэн гэдэг үгийн учир.* Монгол хэл зохиол түүх. 1958, 8-р хугацаа. (монгол бичгээр)

Дорнотив. *Ойрад цааз.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1985. (монгол бичгээр)

Норжин, Чойдандар. *Нутгийн аялаганы үгсийн хураангуй.* Үндэсний хэвлэлийн хороо. 1992. (монгол бичгээр)

Хайрхан Х., Сод Б. *Монгол хэл хийгээд монголчуудын уламжлалт ёс.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 2001. (монгол бичгээр)

Халимаг Жангар. Текст харгуулал хийгээд үгсийн тайлбар. Эмх. Балжайн Дамринжав. 2002. (монгол бичгээр)

Цэцэнцогт. *Монгол үгсийн язгуурын толь.* Өвөр Монголын Ардын хэвлэлийн хороо. 1988. (монгол бичгээр)

Элдэнтэй, Ардажав. *Монголын нууц товчоо: Сийрүүлэл тайлбар.* Өвөр Монголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо. 1986. (монгол бичгээр)

哈斯巴特尔:《从蒙古语〈女婿〉〈媳妇〉程未来源看婚俗的变迁》,《内蒙古大学学报》,1994年第1期。

文英:《论蒙古族亲属称谓中所反映的民族文化现象》,《西北民族学院学报》,2003年第1期

芬兰, G. J 兰司铁著, 陈伟等译《阿尔泰语言学导论》, 中国社会科学出版社, 1981年.

都兴智:《明代蒙古人的婚俗》,《北方民族》1994年第2期

Abstracts

Xinjiang Oirad Mongolian Kinship Words and Its Social Culture

Key Words: *Oirad Mongolian; Oirad Dialect; Kinship Words; Social Cultural*

Oirad Mongolian kinship words system is not only one of the most important parts of Oirad Mongolian lexicon, but also the cultural words that could denote the unique feature of Oirad Mongolian society and culture. This paper aims to introduce the distinctive feature and cultural connotation of Oirad Mongolian kinship words through the analysis of kinship words in Oirad Dialect.